

# Сарын урьдчилсан төлөв

## 2025 ОНЫ 02 ДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

### ТАНЫ АНХААРАЛД

Дэлхийн цаг уурын байгууллагаас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэг нь 1991–2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг. Сарын цаг агаарын урьдчилсан мэдээнд сарын дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны хэмжээг дараах дөрвөн бүс нутгаар тус бүрээр урьдчилан мэдээлнэ.


- о **Баруун** (Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор)
- о **Төв** (Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул)
- о **Зүүн** (Хэнтий, Дорнод, Сүхбаатар)
- о **Говь** (Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Сүмбэр)

Цаг агаарын үзэгдэл нутгийн 30 хувиас хэтрэхгүйгээр зурвас газраар ажиглагдах тохиолдолд "зарим газраар", 30-70 хувьд "ихэнх нутгаар", 70 хувиас дээш нутгийг хамрах тохиолдолд "бүх нутгаар" гэсэн нэр томъёо хэрэглэдэг. Дулааны улиралд агаарт болон хөрсний гадарга дээр температур 0°-аас бага болж хүйтрэхийг "цочир хүйтрэл" гэнэ.


Сар, улирлын урьдчилсан мэдээний талаар лавлах бол Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн 11-326606 утсаар холбогдох болон "Цаг агаар, орчны тоон загварчлал, судалгааны хэлтэс" -ээс тодруулах боломжтой.

Уур амьсгалын тойм

Хоёрдугаар сарын агаарын температурын олон жилийн дундаж нь Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөлийн ихэнх, Архангайн баруун, Сэлэнгийн хойд, Төвийн зүүн хойд хэсгээр **-22...-28°C**, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговийн өмнөд хэсэг болон Өмнөговийн ихэнх нутгаар **-8...-14°C**, бусад нутгаар **-14...-22°C** хүйтэн байдаг (**Зураг 1**).




Хоёрдугаар сарын агаарын дундаж температурын олон жилийн явцаас онцолбол 1984 онд ихэнх нутгаар, ОЖД-аас 3–5°C, нутгийн баруун хагаст 6–10°C-аар хүйтэн байсан бол 2005 онд нийт нутгаар ОЖД-аас 8–14°C-аар хүйтэн байсан ба тус онд шөнийн үнэмлэхүй бага температур Увс, Завхан, Хөвсгөлийн хойд хэсгээр 47–55°C, бусад нутгаар 38–44°C хүрсэн байна. Харин 1980, 1981, 1983, 1986, 1988, 1996, 2000, 2008, 2010, 2012, 2014, 2019 онуудад ихэнх нутгаар, 1987, 2001, 2013 онуудад нутгийн зүүн хагаст ОЖД-аас 1–6°C-аар хүйтэрчээ. Ихэнх нутгаар дулаарсан жилүүдийг аваад үзвэл **хамгийн дулаан 2 дугаар сар 2007 болон 2021 онуудад тохиосон бөгөөд 2007 онд нийт нутгаар, 2021 онд баруун, төв, говийн аймгуудын нутгаар ОЖД-аас 6–10°C-аар дулаан байсан бол 1979, 1993, 1998, 1999, 2004, 2015, 2017, 2020, 2023 онуудад ихэнх нутгаар, 2002 онуудад нутгийн зүүн хагаст ОЖД-аас 1–6°C-аар дулаан байсан байна (Зураг 2).**



**Зураг 2. 2-р сарын агаарын температурын олон жилийн явц**  
**[Улаан – ОЖД-аас дулаан, хөх – ОЖД-аас хүйтэн]**


Цас ОЖД-аар Завханы ихэнх, Хөвсгөлийн баруун хойд, Сэлэнгийн зүүн, Төвийн зүүн хойд хэсгээр 2–4 мм, бусад нутгаар 0–2 мм цас ордог байна (Зураг 3).



**Зураг 3. 2-р сарын нийлбэр хур тунадасны ОЖД, [мм]**

Харин 1981–1983, 1986, 1987, 1992, 1994, 1995, 1997–2001, 2008, 2012 онуудад ихэнх нутгаар олон жилийн дунджаас бага цас орсон бол 1988, 1990, 1993, 1996, 2002–2007, 2009–2011, 2013–2020 онуудад ихэнх нутгаар олон жилийн дунджаас 1–3 дахин их цас орсон байна. Олон жилийн дунджаар

Увс, Завхан, Хөвсгөлийн хойд хэсгээр 10–18 см, бусад нутгаар 3–8 см зузаан цасан бүрхүүл тогтдог бөгөөд дээр дурдсан жилүүдэд цасан бүрхүүлийн дундаж зузаан 20–30 см–т хүрч өвөлжилтийн байдал ихээхэн хүндэрч байжээ (**Зураг 4**).



**Зураг 4. 2-р сарын нийлбэр хур тунадасны олон жилийн явц**  
 [Ногоон – ОЖД-аас ахиу, шар – ОЖД-аас бага]


#### ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

**Баруун аймгуудын нутгаар.** Энэ сард агаарын дундаж температур болон хур тунадас нийт нутгаар ОЖД-ийн орчим (**Зураг 5, 6**) байх төлөвтэй байна. Агаарын температур, хур тунадасны явцыг (**Зураг 7**)–д харуулав. Сарын эхээр ихэнх нутгаар агаарын температур өдөртөө бага зэрэг уярах төлөвтэй байна. Цаашдаа нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд үеүдэд ихэнх нутгаар ОЖД-аас 1–3°C-аар хүйтэн байна. Бусад хугацаанд ОЖД-ийн орчим болон дунджаас бага зэрэг дулаан байх төлөвтэй байна. Хур тунадас нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхэн болон гуравдугаар арав хоногийн эхэн үеүдэд зарим газраар бага зэргийн цас орж, салхи шуургатай байх төлөвтэй байна.


**Төвийн аймгуудын нутгаар.** Энэ сард агаарын дундаж температур болон хур тунадас нийт нутгаар ОЖД-ийн орчим (**Зураг 5, 6**) байх төлөвтэй байна. Агаарын температур, хур тунадасны явцыг (**Зураг 8**)–д харуулав. Сарын эхээр ихэнх нутгаар хүйтэн жиндүү байх төлөвтэй байна. Цаашдаа нэгдүгээр арав хоногийн сүүлч болон хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд үеүдэд ихэнх нутгаар ОЖД-аас 1–3°C-аар хүйтэн, бусад хугацаанд ОЖД-ийн орчим болон дунджаас бага зэрэг дулаан байх төлөвтэй байна. Хур тунадас нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, хоёр болон гуравдугаар арав хоногийн сүүлч үеүдэд ихэнх нутгаар бага зэргийн цас орж, зарим газраар салхи шуургатай байх төлөвтэй байна.

**Зүүн аймгуудын нутгаар.** Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД-аас дулаан (**Зураг 5**), хур тунадас нутгийн өмнөд хэсгээр ОЖД-аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим (**Зураг 6**) байх төлөвтэй байна. Агаарын температур, хур тунадасны явцыг (**Зураг 9**)–д харуулав. Сарын эхээр ихэнх нутгаар хүйтэн жиндүү байх төлөвтэй байна. Цаашдаа хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд үеүдэд ОЖД-аас 2–5°C-аар хүйтэн, бусад хугацаанд ОЖД-ийн орчим болон дунджаас бага зэрэг дулаан байна. Хур тунадас нэг болон хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд үеүдэд ихэнх нутгаар цас орж, зарим газраар салхи ширүүсч, цасан шуурга шуурч болзошгүй байна.


**Говийн аймгуудын нутгаар.** Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД–аас дулаан (Зураг 5), хур тунадас Өмнөговь, Дорноговийн зарим газраар ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим (Зураг 6) байх төлөвтэй байна. Агаарын температур, хур тунадасны явцыг (Зураг 10)–д харуулав. Нэгдүгээр арав хоногийн дунд болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд үеүдэд ихэнх нутгаар ОЖД–аас 1-3°C-аар хүйтэн, бусад хугацаанд дунджийн орчим болон дунджаас бага зэрэг дулаан байх төлөвтэй байна. Хур тунадас нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлч үеүдэд ихэнх нутгаар бага зэрэг цас орж, зарим газраар салхи ширүүсч, явган болон шороон шуурга шуурч болзошгүй байна.




**Зураг 5. 2025 оны 2-р сарын агаарын дундаж температурын урьдчилсан төлөв, С° [Д-агаарын температур ОЖД–аас дулаан, Н-агаарын температур ОЖД–ийн орчим]**



**Зураг 6. 2025 оны 2-р сарын нийлбэр хур тунадасны урьдчилсан төлөв, мм**  
**[И-хур тунадас ОЖД-аас ахиу, Н-хур тунадас ОЖД-ийн орчим]**




**Зураг 7. Баруун аймгуудын нутгийн 2025 оны 2-р сарын температур, хур тунадасны явц**  
**[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,**  
**үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]**



**Зураг 8. Төвийн аймгуудын нутгийн 2025 оны 2-р сарын температур, хур тунадасны явц**

**[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,**


**үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]**



**Зураг 9. Зүүн аймгуудын нутгийн 2025 оны 2-р сарын температур, хур тунадасны явц**

**[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,**

**үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]**



**Зураг 10. Говийн аймгуудын нутгийн 2025 оны 2-р сарын температур, хур тунадасны явц**  
**[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж**  
**температур ОЖД-аас дулаан,**  
**үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын**  
**дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]**

### **ЗӨВЛӨМЖ**

Сарын эхээр нутгийн зүүн хагаст хүйтэн жиндүү байдал хадгалагдах төлөвтэй байгаа бөгөөд цаашдаа нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд үеүдэд ихэнх нутгаар ОЖД-аас 1–3°C-аар хүйтэн, бусад хугацаанд ОЖД-ийн орчим болон дунджаас бага зэрэг дулаан байх төлөвтэй байна. Нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар цас орж, салхи зарим газраар ширүүсч, цасан болон шороон шуурга шуурах төлөвтэй байна. Харин гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлч үеүдэд бага зэргийн цастай, салхи шуурга ихтэй байх магадлал ажиглагдаж байгаа тул хол замд гарахдаа богино хугацааны урьдчилсан мэдээг тогтмол авч ашиглахыг зөвлөж байна. Мөн баруун аймгуудын ихэнх сумдын нутгаар зудын нөхцөл байдал үүссэн, зүүн аймгуудын нутгаар хангалттай хэмжээний цасан бүрхүүл тогтоогүйгээс газар хуурай, хөрс хангалттай чийг хуримтлуулаагүй тул салхи шуургатай үед нөхцөл байдал хүндэрч болзошгүй байгаа тул малчид өвс тэжээлийн нөөцөө хангалттай бэлтгэхийг зөвлөж байна.